



# ЭРТЛЭН СЭРЭМЖЛҮҮЛЭХ СИСТЕМ ГЭЖ ЮУ ВЭ?

## Early Warning System

Хөгжлийн донорууд болон тэдгээрийн төслүүдийн үйл ажиллагаа нь тухайн нутгийн газар ус ба ард иргэдэд хэрхэн нөлөөлөх талаар хүртээмжтэй, цагаа олсон мэдээлэл байдаггүй нь даян дэлхийн хүн амд тулгарч буй томоохон асуудал болоод байна.

Эртлэн сэрэмжлүүлэх систем нь хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжихээр төлөвлөгдөж буй, хүний эрх ба байгаль орчинд халдах магадлалтай төслийн талаар орон нутгийнхан болон тэднийг дэмждэг байгууллагуудыг баталгаатай мэдээллээр хангах, нөлөөллийн стратегиа төслийн санхүүжилт нь батлагдахаас өмнө боловсруулах, үр дүнтэй нөлөөлөхөд нь туслах зорилготой юм.

Эртлэн сэрэмжлүүлэх систем нь нутгийн иргэд, тэднийг дэмждэг байгууллагуудтай мэдээлэл, зөвлөлгөө, арга хэрэгслүүд болон нөөцийн мэдээлэл солилцон хөгжлийн оролцогч талуудад түгээдэг. Солилцох мэдээлэлд хөгжлийн санхүүгийн байгууллагуудын төслийн болон түүнд оролцогч хувийн хэвшлийн талаарх мэдээлэл мөн нутгийнхны өөрийн судалгааны мэдээлэл зэрэг орно.

Хэдийгээр Эртлэн сэрэмжлүүлэх систем нь 13 хөгжлийн санхүүгийн байгууллагын төслүүдийн мэдээллийг нягтлан оруулж, дүгнэн стандартчилдаг ч энэ нь зөвхөн мэдээллийн сан биш юм. Эртлэн сэрэмжлүүлэх систем нь орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болон кампанит ажилд шаардлагатай мэдээлэл хүргэхийг эрмэлзэж хөгжлийн төлөвлөлт дээрээс доош явагдаж байгааг өөрчлөх нутгийнхны санаачлагыг дэмжих зорилготой.

Эртлэн сэрэмжлүүлэх систем нь орон нутгийн хөгжлийн тэргүүлэх асуудлыг тодорхойлж, тактикийн дэмжлэг үзүүлэх, нутгийнхны авах нэгдмэл арга хэмжээнд тулгуурлана. Шийдвэр гаргагчдад хүрч ажиллах, нутгийнхны өөрийн судалгаа гүйцэтгэх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хөшүүрэг болсон санаануудыг ойлгох, гомдол гаргах, орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зэрэг нь нутгийнхны авах нэгдмэл арга хэмжээнд багтаж болох юм.

Төлөвлөгдөж буй төслүүдийн талаарх шинэ мэдээлэл болон нийтийг уриалан нэгтгэхэд үзүүлэх дэмжлэг зэрэг нь орон нутгийн өөрийн эрх ашиг ба кампанит ажлаа тодорхойлоход нь мэдээлэл болж өнөөдөр хөгжлийг хэрэгжүүлж байгаа байдлыг өөрчлөх юм. Эртлэн сэрэмжлүүлэх систем нь нутгийнхны өөрсдийн хүсч, төсөөлж байгаа хөгжлийг тодорхойлоход шаардагдах мэдээлэл ба өргөн хүрээтэй чиг хандлагын дүн шинжилгээгээр эртлэн хангаж тавуу тал олгох зорилготой.

Илүү мэдээллийг [www.rightsindevelopment.org/ews](http://www.rightsindevelopment.org/ews)-ээс, эсвэл [ews@rightsindevelopment.org](mailto:ews@rightsindevelopment.org) и-мэйл хаягаар авна уу?